ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Нам Ян Жугийн гудамж 32/1,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13335
Утас: 45 39 94, Факс: (976-11) 45 86 99,
Цахим шуудан: info@nccd.gov.mn,
Цахим хуудас: www.nccd.gov.mn

2026.11.11 № 3-2/1515.

танай _____-ны №_____-т

ГАР УТАСНЫ АППЛИКЕЙШН, ВЭБ УДИРДЛАГЫН ЦАХИМ БҮРТГЭЛИЙН СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭГЧ НАРТ

Үнийн санал авах тухай

ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн үйл ажиллагааны хүрээнд болзошгүй цар тахлын үед ХДХВ, ДОХ-той хүмүүст үзүүлэх тусламж, үйлчилгээг дижитал хэлбэрээр хүргэх, эмчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор гар утасны аппликейшнийг хөгжүүлэн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Энэхүү аппликейшн, удирдлагын системд нэмэлт хөгжүүлэлтийг 6,000,000 (зургаан сая) төгрөгийн төсөвт өртгөөр хийлгэх тул гар утасны аппликейшн, вэб удирдлагын цахим бүртгэлийн систем хөгжүүлэгч компаниуд үнийн саналаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дах заалтын дагуу 2026 оны 11 дүгээр сарын 18-ны дотор ирүүлнэ үү.

Саналыг байгууллагын албан тоотоор баталгаажуулж холбогдох материалын бүрдэл (улсын бүртгэлийн гэрчилгээ, ижил төстэй ажлын гэрээ)-ийг ханган tender@nccd.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

ЗАХИРАЛ С.ЭНХБОЛД

9024040027
9077001 ГСТ7072

Халдварт өвчин судлалын үндэсний
төвийн ерөнхий захирлын 2026 оны
5-2/1515 дугаартай албан бичгийн хавсралт

ХДХВ, ДОХ-ТОЙ ХҮМҮҮСТ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГАР УТАСНЫ БОЛОН ВЭБ УДИРДЛАГЫН ЦАХИМ БҮРТГЭЛИЙН СИСТЕМИЙН НЭМЭЛТ ХӨГЖҮҮЛЭЛТ

Гүйцэтгэх ажлын жагсаалт

№	Ажлын нэр	Гүйцэтгэх ажлын товч тодорхойлолт
1	Цаг захиалгын системийн сайжруулалт	Цагийн хуваарь, төлөвийн удирдлага, өвчтөн болон ажилтнаас цаг захиалах боломж, давхардсан цагийн хяналт, цаг өөрчлөлт болон цуцлалтын түүхийг сайжруулах.
2	Үзлэгийн бүртгэлийн сайжруулалт	Үзлэгийн мэдээлэл, эмчийн тэмдэглэл, эмийн бүртгэл болон дараагийн хяналтыг уялдуулах, мэдээллийн бүрэн бүтэн байдал, хадгалалтын шалгалтыг сайжруулах.
3	Үзлэгийн нэгдсэн бүртгэл	Үзлэгийн түүхийг нэгдсэн жагсаалтаар харах, хайх, шүүх, эрэмбэлэх, өмнөх бүртгэлийг харах болон өөрчлөлтийн түүхийг хадгалах.
4	Эмийн бүртгэл, хугацааны хяналт	Эмийн нэгдсэн жагсаалт, эм сонголт, хэрэглэх хугацаа, дуусах өдрийн автомат тооцоолол, эмийн төлөвийн хяналт, хайлт болон шүүлтийг хөгжүүлэх.
5	Эм дуусахаас өмнөх эргэн холбоо	Эмийн хугацаа дуусахад 0–6 хоног үлдсэн өвчтөнийг автоматаар илрүүлэх, эргэн холбогдох жагсаалт үүсгэх, холбогдсон үр дүн болон дараагийн холбогдох хугацааг бүртгэх.
6	Хяналтаас тасарсан өвчтөний эргэн дуудалт	Сүүлийн 90 хоногт үзлэгт хамрагдаагүй өвчтөнийг илрүүлэх, анхаарах нөхцөлийг харуулах, эргэн дуудалтын үр дүн, түүх болон хяналтын төлөвийг удирдах.
7	Өвчтөний мэдээллийн нэгдсэн тойм	Өвчтөний код, холбоо барих мэдээлэл, үзлэгийн түүх, эмийн мэдээлэл, дараагийн цаг болон эмчилгээний хяналтыг нэг дэлгэцээс харах боломж бүрдүүлэх.
8	Хяналтын самбар (Dashboard)	Өдөр тутмын цаг захиалга, эмийн хугацаа, хяналтаас тасарсан өвчтөн, анхаарал шаардлагатай мэдээлэл болон зурвасын статистикийг нэгтгэн харуулах.
9	Нэгдсэн хайлт, шүүлт, тайлан	Үндсэн бүртгэлүүдийн хайлт, шүүлт, эрэмбэлэлт, хуудаслалтыг нэг стандарттай болгох, эрхийн хязгаарлалттай Excel экспорт хөгжүүлэх.
10	Өвчтөний эмчилгээний биелэлтийн тэмдэглэл	Өвчтөн өөрийн эм хэрэглэсэн эсэхийг тэмдэглэх, эмч тухайн мэдээллийг харах, эмчилгээний биелэлтийг хянах боломж бүрдүүлэх.
11	SMS болон Telegram мэдэгдэл	Сонгосон өвчтөнүүдэд ерөнхий агуулгатай SMS илгээх, чатад зурвас ирэхэд Telegram bot-оор эрх бүхий ажилтанд мэдэгдэл хүргэх, хүргэлтийн төлөвийг бүртгэх.

12	Нэвтрэлт, хэрэглэгчийн эрх, мэдээллийн аюулгүй байдал	Өвчтөний код болон OTP нэвтрэлт, session хамгаалалт, хэрэглэгчийн эрхийн хяналт, API болон веб хамгаалалт, үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийн нууцлалыг сайжруулах.
13	Хэрэглэгчийн интерфэйс, хүртээмж	Монгол хэлний нэршил, интерфэйсийн нэгдмэл байдал, гар утасны дэлгэцэд нийцэх байдал, WCAG AA хүртээмж, алдаа болон сүлжээ тасарсан үеийн ажиллагааг сайжруулах.
14	Системийн найдвартай ажиллагаа, автомат шалгалт	Автомат тест, программын сангийн шинэчлэл, системийн ажиллагааны хяналт, алдааны мэдэгдэл, өгөгдлийн сангийн нөөцлөлт, сэргээх болон хувилбар буцаах боломжийг хэрэгжүүлэх.
15	Баримтжуулалт, сургалт, хүлээлгэн өгөх	Шинэчлэгдсэн эх код, техникийн болон хэрэглэгчийн заавар, аюулгүй байдлын тайлан, шалгалтын үр дүн, сургалтын материал бэлтгэх, холбогдох ажилтнуудад сургалт зохион байгуулах.

Технологийн болон хэрэгжүүлэлтийн нөхцөл

- Одоо ашиглаж буй системийн архитектур, эх код, өгөгдлийн бүтэц болон ажиллаж байгаа интеграцтай нийцүүлэн нэмэлт хөгжүүлэлт хийнэ.
- Одоо байгаа эмнэлгийн бүртгэлийн түүх, мэдээллийн бүрэн бүтэн байдал болон үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүй.
- Веб удирдлагын систем, Android, iOS аппликейшн болон серверийн үйлчилгээнд хийсэн өөрчлөлтүүд хоорондоо бүрэн уялдсан байна.
- Chatwoot, SMS API, Telegram Bot API болон Push Notification үйлчилгээний интеграцыг одоо ашиглаж буй шийдэлтэй нийцүүлэн хөгжүүлж, хэвийн ажиллагааг шалгана.
- Хөгжүүлэлтийн явцад өвчтөний хувийн болон эрүүл мэндийн нууц мэдээллийн хамгаалалтыг хангана.

Шинэчлэлтийн дараа системийн үндсэн ажиллагаа болон интеграцуудыг туршиж, илэрсэн алдаа, доголдлыг засварласан байна.